

АЯН ЗАМЫН
ТЭМДЭГЛЭЛ

ЧИНГИСИЙН МЭНДЭЛСНИЙ
800 ЖИЛИЙН ОЙГ
ТЭМДЭГЛЭСЭН ТУХАЙ
ДУРДАТГАЛ

Н. Ишжамц

1206 онд Монголын феодалын үндэсний нэгдсэн тулгар төр улс байгуулагдаж, монгол угсаатан дэлхий нийтийн түүхийн тавцан дээр улс төр, цэргийн хүчирхэг гүрэн болж гарч ирсэн нь түүнийг үндэслэн байгуулагч Чингис хааны нэртэй шууд холбоотой. Чингис хаан Ази, Европын улс орнуудын эсрэг их хэмжээний аян дайн хийж, эзлэн авсан байлдан дагуулагч, Монголын эзэнт гүрнийг тэрлэн байгуулсан Төв Азийн нүүдэлчин улс түмний улс төр, цэргийн томоохон зүтгэлтэн байв. Өвөр хоорондоо болон дотор зуураа нийлэн нэгдэж чадахгүй, үргэлжид дайн дажин хийж байсан их, бага улс гүрнүүдийг нэгтгэн, нэг үе ихээхэн өргөн уудам газар нутагт дайн дажныг зогсоож, «татар-монголын энхжин ертөнц» бий болох үндсийг тэр хүн анх тавьсан байна. Тийм учир түүний нэр алдар сайн, саармаг алинаар ч дэлхий дахинд цуурайтан үлдсэн ажээ. Сүүлийн үе хүртэл алс холын аливаа улс гүрэнд ажил төрлөөр аялан явахад «Монгол» гэхээр «Хятадынх уу, Оросынх уу?» хэмээн гайхаж, «Үгүй, тэр хоёрын чинь хооронд биеэ даасан БНМАУ гэж байдаг юм шүү дээ, Та мэдэхгүй гэж үү?» гэхээр сая ухаарч «Аа тийм, Чингис хаан, Чингисийн Монгол, тийм биз дээ, та над Чингис л гээд хэлчихсэн бол би тэр доор чинь ойлгох байсан» гэх зэрэг яриа болдог байв.

XIV зууны 60-аад оны үест Монголын эзэнт гүрэн мөхсөний дараа Чингисийн нэр сүр, дүр төрх нь тусгаар тогтносон Монгол улс, түүний төрийн сүлд хийморь болж, XVII зууны эцсээс XX зууны эхэн хүртэл Монгол дахь манж, хятадын ноёрхлын үед тус орны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний туг болж, улс төр, үзэл санааны чухал үүрэг гүйцэтгэж байв. 1921 онд Монголд ардын хувьсгал ялсны дараа, ялангуяа дэлхийн хоёрдугаар дайны үед улс орныг батлан хамгаалах, харийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэх, Барга, Өвөр Монголыг чөлөөлөх үйл хэрэгт манай улсад Чингисийн цэргийн түмт, Мянгат, зуутын зэрэг аравтын зохион байгуулалтыг тусгай зохион байгуулагдсан, Мижид жанжин тэргүүтэй сайн дурын морьт отряд идэвхтэй зүтгэж, гавьяа байгуулж, нам, улс, ард түмний зүгээс өндөр үнэлэлт авсныг түүнд гар бие оролцон явсан ахмад үеийнхэн, эх орны түүх сонирхдог залуус эрх биш мэдэж, санаж буй биз ээ.

Гэтэл 40-өөд оны дунд үеэс сталинч түүх судлал, уран зохиолд хүннү, түрэг, монгол зэрэг Төв Азийн нүүдэлчдийн амьдрал, хөгжил, тэдний байгуулсан эзэнт гүрнүүдийн түүхийг харийн түрэмгийллийн эсрэг ард түмнээ эх оронч үзлээр зоригжуулан хүмүүжүүлэх нэрийн доор дан ганц хараар будаж, хараан зүхээд ялангуяа Чингис хааныг хүн танихын аргагүй болтол муугийн муугаар дүрслэн зураглах болжээ. Тэр бурангуй үзэл нь тухайн үеийн намуудын удирдлага, улс төр, үзэл суртлын шугамаар манай нийгмийн шинжлэх ухаан, ардын боловсролын бүх салбарт тулгагдан нэвтэрч, удтал зонхилв. Төв Азийн нүүдэлчин улс түмэн, түүний дотор мөн монголчуудын түүх,

соёл, Чингисийн дүр төрхийг бодитой гаргасан эрдэмтэн мэргэд, төрийн зүтгэлтэн, эгэл жирийн ард цөм «үндэсний үзэлтэн», «үндсэрхэг үзэл номлогчид» болж, адаг сүүлд нь амьдрал ахуй, аль байдгаараа насан турш хохирох болсоор ирснийг хэн бүхэн мэднэ. 1984, 1985 оноос эхлэн өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээний ачаар Чингисийн тухай үнэний зах зухыг цухуйлгаж, ам нээж, үг хэлэх боломжтой болж байна.

1962 онд манайд Чингисийн мэндэлсний 800 жилийн ойг хэрхэн яаж тэмдэглээд дараа нь яаж буруудаж муугаа үзэцгээсэн нь нарийн утга учир бүхий түүхэн үнэний нэг мөн болох тул өнөөгийн залуус, хойч үеийнхэн тэр тухай товч боловч тодорхой мэдлэг, тоймтой ойлголт авч үлдвэл зүгээр юм. Тэгэхээр Чингисийн 800 жилийн ойг тэмдэглэхэд зохион байгуулах, шинжлэн судлах, бас бус ажил төрөлд оролцсон хүмүүс албан баримтаар хязгаарлахгүй, амин хувийн дурсамж сэтгэгдлийг эргэн санаж, хэвлүүлбэл их хэрэг болно. Түүнд тийнхүү оролцогсдын нэгийн хувьд би тухайн үед үзэж харсан, ухаж ойлгосон зүйлээ эрэгцүүлэн санаж, цэвэр өөрийн гэсэн товч дурсамж бичиж үлдээхийг оролдов.

1961 онд Монголын ШУА, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд шинээр байгуулагдаж ажилдаа ороод Түүхийн хүрээлэн дээр БНМАУ-ын түүхийн гурван боть зохиол зохиох ажил эхэлж, түүний дотор Чингис хаан, Монголын феодалын байлдан дагууллыг ямар хэмжээгээр яаж тусгах тухай асуудал яригдаж байсан. Тэр асуудал чухамдаа эрдэм шинжилгээний шийдвэрлэх асуудал биш, үзэл суртал, улс төрийн нэгэнт аль хэдийн «шийдчихсэн» асуудал байсан тул нэг бодоход бичиж ядамгүй зүйл гэхэд болох талтай байж билээ. Гэтэл 1962 оны өвөл, зуны зааг дээр ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Ширэндэв, Түүхийн хүрээлэнгийн захирал, академич Ш.Нацагдорж, тус хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ч.Далай, бусад түүхчид, нийгэм-судлаачдын анхаарлыг онцгой татсан нэг асуудал гарсан нь Чингисийнх байв. Нэн түрүүнд БНХАУ-д тухайлбал, Өвөр Монголд Чингисийн мэндэлсний 800 жилийн ойг тусгайлан тэмдэглэх болсон бололтой, чухам ямар хэмжээнд хэзээ яаж тэмдэглэх гэж байгаа бол гэсэн асуудал гарсан юм. БНХАУ-д Чингисийг Монгол төдийгүй, Хятадын төрийн томоохон зүтгэлтэн, XIII—XIV зууны Юан улсыг үндэслэн байгуулагч хэмээн үзэж, ойг нижгэр тэмдэглэх болсон учир манайд тэмдэглэхгүй өнгөрч болохгүй, нэгэнт тэмдэглэвэл жол юм хийж болохгүй болсон юм. 1962 оны хавар Чингисийн мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлэх тухай Улс төрийн товчооны тогтоол гарч, академи, түүхийн хүрээлэнд тодорхой үүрэг, даалгавар өгсөн.

Түүхийн хүрээлэн, академиар тэр асуудлыг авч хэлэлцээд, Чингисийн ойд зориулан нийслэл Улаанбаатар хотод эрдэм шинжилгээний бага хурал хийх, төрсөн нутагт нь хөшөө дурсгал босгох, жич шуудангийн хэдэн янзын марк гаргах зэрэг ажил зохиох нь зүйтэй гэж үзсэн. Ой тэмдэглэх бэлтгэл ажлын хуваарь гаргахад Чингисийн мэндэлсэн билигийн улирлын гуравдугаар жарны усан морин жилийн зуны эхэн сарын 16-ны өдөр нь одоо дэлхий нийтээр мөрдөгдөж байгаа Европын он тооллын хэдэн оны хэдэн сарын хэдний өдөр болохыг тодорхойлон ёслол үйлдэж, бага хурал хийх өдрийг товлон тогтоох асуудал бидний хэдэн ажилтанд ногдсон. Бид монгол, Хятад, Төвд түүхийн сурвалжийн мэдээг европын тоололтой харшуулж 1162 оны 5-р сарын 31-ний орчим тохиолдох байдал учрыг гарган Гандан хийдийн хамба лам Гомбожавыг монгол, төвд зурхайн аргаар шалгаж, тодруулж өгөхийг хүссэн. Хэд хоногийн дараа бид Гандангийн зурхайч нартай уулзаж, тэдний зурхайлан бодсон үр дүнтэй танилцахад 5-р сарын 31

мөн хэмээн тэд нотолж өгсөн. Тэгээд ой тэмдэглэх ёслол, бага хурлыг 31-ний өдөр хийх болсон юм. Одоо манай зурхайч нар Чингисийн төрсөн өдрийн 5-р сарын 1, 6-р сарын 7, 12 гэх мэт янз бүрээр үзэж байгаа бөгөөд жил бүрийн зуны эхэн сар өөр өөр өдөр эхлэх тул он өнгөрөх тутам тэр хуучны 4-р сарын 16-ны өдөр нь янз янзын өдөр болж үзэгдэх явдал аяндаа гарах боловч чухамхүү 1162 оныхоор нь бодож, нэгэнт ойг нь тэмдэглэж, дотоод, гадаадад зарласан 5-р сарын 31-нээр нь болзолтой ч гэсэн товлон тогтоовол цаашдаа он жил улирах бүрийг ойг тогтмол нэг өдөр тэмдэглэж байхад ажил төрлийн хувьд арай тохиромжтой байж юуны магад.

Чингисийн ойн хурлыг хаана хийх вэ? Хэн хурлыг удирдаж, хэн хэн илтгэл тавьж, үг хэлэх вэ гэх зэрэг асуудал академи дээр анх хэлэлцэх үеэр Түүхийн хүрээлэнгийн секторын эрхлэгч Н.Сэр-Оджав нарын зэрэг зарим ажилтан нэгэнт Монголын төрийг үндэслэн байгуулагчийн ойг хийх гэж байгаа болохоор засгийн ордонд, Ардын Их Хурлын танхимд хийхэд болохгүй газаргүй гэх зэрэг санал гаргаж, бусад нь академи дээрээ хийсэн нь аюулгүй биз дээ гэж байж билээ. Үнэхээр Чингисийн ой тэмдэглэх асуудал улс төрийн товчоон дээр яригдах үеэр тэр тухай яриа болоход Ю.Цэдэнбал дарга Их Хурлын танхим энэ тэр гэх шиг та нар чинь юу яриад байна? гэсэн гэдэг. Тэгээд ойг Улсын нийтийн номын сангийн 2-р давхрын 106-р танхимд тэмдэглэх болсон юм. Тэр танхим 250-иад хүний суудалтай, гэтэл олонхий хурал зөвлөлгөөнд хүн цуглаж өгдөггүй байсан учир хоосон суудал гаргахгүйн тул 500 орчим урилгын билет хэвлэж тараах хэрэгтэй байдаг байсан. Чингисийн ойгоор хүн цуглуулахын тул мөн тэр хэмжээний билет хэвлэж бэлдээд байв. Гэтэл хүмүүс маш сонирхож, энд тэндэхийн байгууллага болон хувь хүн урилгын билет урьдчилж захиалан бэлчилж авсаар нийтэд тараахын өмнө нэлээд цөөрүүлж орхисон байв. Тэр тухайд бид санаа авч хэвлүүлсэн билетийг бүгдийг тараахаа больж, зөвхөн суудлын тоогоор тааруулж тараав. Хурал болох өглөө урилгатай, урилгагүй маш олон хүн цуглаж, танхимд сул суудал эс үлдсэнээр үл барам бүх завсар зайгаар хүн чигжиж суугаад тэргүүлэгчдийн суудлын ар өвөр, хажуу хавиргаар ч олон хүн шахалдаж суучихаад гадна талд толгой дээрээ сандал барьсан, бариагүй өчнөөн төчнөөн хүн босоогоор чихцэлдэн зогсож байв. Танхим 2-р давхарт байдаг боловч коридор, шат, 1-р давхарт хүртэл дүүрэн хүнтэй болсон байв. Тэдэнд зориулж бид яаралтай хөдлөн танхимын гадна талд, коридорт, түүнчлэн 1-р давхарт микрофон тавихад хүрсэн. Академийн намын хорооноос ойн хурал хийхэд Чингисийг хэт магтаж болохгүй, академич Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн нарт энэ талаар чи өөрөө тус тусад нь ганцаарчилж хэл, харин академич Лувсанвандан гуайгаар болгоомжтой үг хэлүүлэхийг бод гэж үүрэг өгөв. Гэтэл академич Б.Ринчен, Ц. Дамдинсүрэн хоёртой би тааралдсангүй. Ш. Лувсан вандан гуайг арай чарай олж, үг хэлүүлэх болсныг мэдэгдэн зөвшөөрүүлэв. Хурал эхлэхийн өмнө ирсэн Лувсанвандан гуайд хүртэл сул суудал олдоогүй учир тэргүүлэгчдийн суудлын хажуу талд сандалгүй бөөгнөрөн суусан хүмүүсийн дунд орж суусан байхад нь олж, захисан зүйлийг хэлсэн. Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга байсан Ч. Далай БНХАУ-д суугаа Монголын элчинд очиж ажиллах болсны учир би түүний оронд томилогдоод тийм үүрэг даалгавар намын хорооноос авч хэрэгжүүлж ядан байсан нь тэрээ.

Чингисийн ойг тэмдэглэх ёслолын эрдэм шинжилгээний бага хурал, хөшөө дурсгал босгох, марк хэвлүүлэх зэрэгт тусгай төсөв батлуулж гаргуулах болсон бөгөөд тооцоолсны эцэст хэдэн зуун мянган төгрөг хэрэгтэй болох нь мэдэгдсэн Зөвхөн хөшөө босгоход 190 гаруй

мянган төгрөг шаардагдах байв. Хөшөө болон бусад зүйлийн их хэмжээний зардлын төсөв үйлдэж, гол нь Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга дээр орж албан ёсны зөвшөөрөл давхар авах хэрэгтэй болсон. Тийм их мөнгөний төсвийг юун дээр ч бүрэн баталж өгдөггүй, ихэнхийг хасдаг байсан тул үүн дээр бүүр ч хатуурхана гэж бид «мэдэж», хоорондоо ярилцан, тийм асуудлаар том дарга нар дээр орохоос халширч байж билээ. Тэгээд төсвийн төслийг нэг залуудаа бариулж, үндэслэл сэлтийг нь сайн хэлж өгөөд чи тэр дарга дээр орж, олигтойхон учирлаж яриад асар их хасуулалгүй батлуулж аваад ирэхийг бод, ороход чинь магад олон хүнтэй байх бий, цөөн байсан ч хэзээ хүлээж авах вэ, бүү мэд, бид шууд ярьж болохгүй байна, юу ч гэсэн чи орж батлуулахыг оролдоод үз, хэрэв бүтэхгүй бол Нацагдорж гуайгаар юм уу, эсхүл бүүр Ширэндэв даргаар яриулахыг бодно, чи юу ч гэсэн урьдчилж очиж байдлыг мэдээд ир, чамд гурав хоногийн хугацаа өгье, тэнд хэдэн өдөр нүдийг нь сахиж байгаад яаж ийж орохыг бод, үүгээрээ битгий эргэлд гэж өглөө эрт явуулсан юм. Гэтэл нөгөө залуу маань үдээс хойш буцаад ирчихсэн сууж байв. Бид баахан гайхаж, чи нөгөө ажлаа хөөцөлдөхгүй, энд яагаад сууж байна вэ? Үндсэн ажлаа чи өөр цагаар хийж амжина шүү дээ, наад төсвөө чи тийм амархан батлуулчихна гэж бодож байна уу? гэсэн чинь залуу маань би үдээс өмнө яваад бүтээгээд ирсэн шүү дээ, тэр дарга дээр чинь ороход нээрэн ч тун бэрхтэй бололтой юм, ороод ч би анхандаа яав ч батлуулж чадахгүй юм байна гэдэг бодол төрсөн, тэгсэн чинь аз таараад орж орхисон гэдэг юм байна. Үгүй чи тэгээд ихэнхийг нь хасуулчихаад ирэв уу? Ер нь чи яаж тийм хурдан орж чаддаг билээ гэсэн чинь залуу маань нэлээд сонин юм ярив. Юу гэвэл, манай залуу ордонд орох түр хугацааны цагаан хуудас бичүүлж аваад тэр том даргын үүдний өрөөнд ортол нь баахан сайд, дарга нар дэс дарааллын журмаар эгнээд суух нь сууж, зогсох нь зогсчихсон байжээ. Нарийн бичгийн дарга нь манай залууг дарааллын ард орж хүлээ гэжээ. Залуу маань олон сайд, дарга нарын ард орж нэлээд зогссон боловч орсон хүн их удах бөгөөд өөрт нь тэр өдөр орж болох шинжгүй гэнэ. Тэгээд буцдаг юм билуу гэж байтал өөрийнх нь өмнө байсан сайд янзтай нэг хүн за, залуу чи юу гэж дарга дээр орох гэж байна? гэж уйдсан хүн яриа өдөх маягтай сонирхон асуужээ. Залууг Чингисийн ойн төсөв батлуулах гэж яваа гэдгийг хүлээлгийн өрөөнд байгсад сонсоод ихэд сонирхон тэр дороо асуулт, хариулт болжээ. Тэгтэл өмнө нь зогсож байсан дарга манай залууг чи тун чухал асуудлаар яваа юм байна. Миний урд ор гээд өөрийнхөө урд оруулчихжээ. Тэгж байтал дараачийн хүн нь бас чи миний урд ор гээд урдаа оруулжээ. Тэд цөм тэр мэтээр урд урдаа оруулсаар байтал залуу маань нэг мэдэхнээ тэр олон сайд, дарга нарын цөмийнх нь урд гарчихжээ. Нарийн бичгийн дарга ч бас гайхаж сонирхсон байдалтай байж байгаад түрүүчийн орсон хүн гармагц залууг оруулжээ. Тэр даргын өрөөнд орж үзвэл өрөө нь их том, эзэн нь нөгөө талд хол гэгч харагджээ. Ойртож очсонд дарга доошоо харж юм уншиж сууснаа залууг хараад нэлээд гайхсан байдалтай, за чи юу гэж явна гэж асуужээ. Төсөв батлуулах гэж ирлээ гэсэн чинь юун төсөв юм гэж дургүй шинжтэй асуугаад тоосон шинжгүй, батлах янзгүй байжээ. Чингисийн ойн төсөв гэхээр харин баахан сонирхсон байдалтай авч үзээд хэсэг зуур хулгаж, яая даа гэсэн байдалтай байснаа ойн асуудлыг мэдэж байсан болтой, илүү дутуу асуулт ч тавьсангүй, төсвийн дээр хэдэн үг бичиж цохолт хийж, залууд өгөөд за яв гэжээ. Залуу маань төсөв батлагдсангүй юу, баахан хасуулж орхив уу гэж гайхан гарч ирээд үзвэл харин бүгдийг ганц ч төгрөг хассангүй баталчихсан байжээ. Тэгж үүрэг даалгавраа амжилттай биелүүл-

чихээд ажил дээрээ ирчихсэн ам бардам сууж байсан ажээ. Чингисийн ойг аятай тэмдэглэж өнгөрүүлэхийг олонхи дарга нар хүртэл эрхбиш монгол хүний хувьд дотроо битүү дэмжиж байсан байдал тийнхүү зугуухан мэдэгдсэн юм.

Чингисийн мэндэлсний 800 жилийн ойн ёслолын эрдэм шинжилгээний бага хурал зэргийг Намын Төв Хорооны Улс төрийн Товчоо ерөнхийдөө нэлээд чухалчлан, ялангуяа үзэл суртал эрхэлсэн нарийн бичгийн дарга байсан Д. Төмөр-Очир дээр тэр ажил тохоогдон хариуцагдсан нь илт байсан. 1962 оны 5-р сарын 31-нд болсон тэр хуралд Төв Хорооноос хэд хэдэн том дарга ирж оролцмоор байсан боловч Төмөр-Очироос бусад нь бараг ирээгүй, бүгд тал тал тийш хөдөө явсан байсан. Өмнө өдөр нь Зөвлөлтийн нэрт эрдэмтэн Майский нарын гурван хүний Чингисийн тухай хамтран бичсэн өгүүллийн товчлол цахилгаан утсаар ирсэн байсан, түүн дотор Чингис хаан бол харь орнуудыг байлдан дагуулагчийн хувьд харгис үүрэг гүйцэтгэсэн санаа цохон тэмдэглэгдсэн байсан. Түүнийг академи дээр бидэнд хурал хийхийн өмнөхөн ерөнхийлөгч үзүүлж танилцуулан, хэт дэвэргэж үл болох тухай давхар дохио өгч санаа авахуулсан болно.

Бага хурлыг дээр дурдсанчлан дотно, гаднагүй маш олон хүн хуран цугларсан 106-р танхимд ерөнхийлөгч Б. Ширэндэв нээж, захирал Нацагдорж Чингис хааны түүхэн ролийн тухай гол илтгэл тавьж, Бира, далай, Ишжамц нарын зэрэг хүмүүс төлөвлөсөн ёсоор үг хэлж, хэдэн цаг үргэлжилсэн. Цугларагсад туйлын сонирхсон байдалтай чив чимээгүй чих тавин сонсч, хааяа алга ташиж байв, Илтгэл хийж, үг хэлсэн хүмүүс Монголын нэгдсэн төрийг байгуулах, Монголд феодализм бүрэлдэн тогтож, монгол угсаатан бүрэлдэхэд Чингисийн гүйцэтгэсэн дэвшилт үүргийн тухай яриад гадагш аян дайн хийснийг нь харгис хэмээн тэмдэглэж, асуудлыг зөв тавьсан бөгөөд хэт дэвэргэн магтаж үндэсний үзэл гаргасан явдал гараагүй юм.

Хуралд бид Б. Ринчен, Ц. Дамдинсүрэн гуай хоёрыг урилга аль хэдийн авсан тул магадтай ирнэ гэж хүлээн харж байсан боловч Ринчен гуай огт үзэгдсэнгүй. Уг нь Чингисийн ойг тэмдэглэхэд, Хэл, зохиолын хүрээлэнг заавал орох ёстой гэж захирал нь байсан Дамдинсүрэн гуайд хэдэн удаа алба, амин хувиар мэдэгдэж хүсэмжилсэн боловч өвгөн академич хаширлаад, үндэсний үзэлд холбогдуулчих тийм ажилд би хэрхэвч оролцохгүй, хүрээлэнгээ ч оруулахгүй гэж тоглоом, шоглоомоор хошигнож, уран үгээр идээд огтхон ч халгаагаагүй юм. Бид тэгээд л Ринчен гуай, Дамдинсүрэн гуай хоёрыг нээрэн оролцохгүй гэж шийдсэн юм байх гэж бодож байсан. Гэтэл хожим нь сонсвол хурал яг эхэлж байхад Ринчен гуай хүрэлцэн ирсэн боловч маш олон хүн цугларчихсан шахцалдаад орохын аргагүй байсан тул хажуугийн өрөөнд ороод микрофоноор хурлын ажиллагаа сонссон байжээ. Дамдинсүрэн гуай анх хэлсэн үгэндээ хүрч хуралд оролцохыг больё гэж шийдээд Дондогийн Цэвэгмид даргын машинд сууж тэр өглөө Налайхын тийш хээр талд гарч зугаалан өнгөрүүлэхээр явжээ. Замаасаа ганц шил «Цагаан Долгор» олж аваад тарган мах авах гэсэн нь бүтсэнгүй, зарим дэлгүүр хаалттай, заримд нь мах байсангүй. Тэгэхээр нь Амгалангийн дэлгүүрээс үхрийн чанасан шийр, тагалаг худалдан аваад цааш хөдөлжээ. Налайхын цаадхи цайдам талд очтол шороо шуураал олигтой болсонгүй. Үдээс хойш хурал тарсан байх гэж бодоод, хотод буцан ирж, Улсын номын сангийн дэргэдүүр хойш өнгөрөх гэвэл хурал тараагүй шинжтэй, гадна нь олон хүн бөөгнөрчихсөн, үг хэлэхийг сонсож байгаа байдалтай байжээ. Дамдинсүрэн гуай тэссэнгүй машинаас бууж, тэдэн дээр очиж, юу сонсч, яаж байгаагийг нь нэг харчихаад явъя гэж бодоод ойртож очжээ. Тэгтэл хүмүүс түүнийг ажиг-

лаж, дам дамаа үг авалцаж зам зай гаргаж урагшлуулсаар нэг мэдэхнээ хурлын танхимын үүдэн дээр хүрч очжээ. Хурал удирдаж байсан Ширэндэв гуай түүнийг хараад дохин дуудаж, шууд дэргэдээ, баруун гар талдаа суулгаж, Майский нарын өгүүллийн товчийг өөр рүү нь түлхэн өмнө нь тавьжээ. Дамдинсүрэн гуай хожим нь тэр тухай бидэнд ярихдаа тэр өгүүллийн товчийг үзэнгүүт Чингисийг ойгоор нь хэт муулж та нарт тийм утас ирүүлснийг үзэнгүүт зэвүү хүрч, гэнэт үг хэлэлтэй санагдаад Ширэндэвт мэдэгдэж, үг хэлсэн юм гэж байсан. Үнэхээр Дамдинсүрэн гуай орж ирсний дараа асар удсангүй босч, ямар ч бэлтгэлгүйгээр үг хэлсэн боловч тэр нь маш гүн гүнзгий утга учиртай, жигтэйхэн цэцэн цэлмэг, уран нарийн болж, цугларагсад дээд зэргээр хөхөн сайшааж, удтал алга нижигнүүлэн ташсан юм. Дамдинсүрэн гуай Чингисийн байлдан дагууллын тухай товч дүгнэж яриад ерөөсөө Чингис хаан бол Монголын төрийн томоохон зүтгэлтэн, түүхт их хүмүүсийн нэг байсан. Гэтэл түүх, уран зохиолд түүний үнэн дүрийг зөв гаргаж чадаагүй байгаа юм, зохиолч Ян бүтээлдээ түүнийг хэт өрөөсгөл муулснаар барахгүй монгол эмэгтэйчүүдийн талаар ч их эв дүйгүй бичсэн байдаг. Хэрэв орос, европын хүнд шар үстэй, цэнхэр нүдтэй эмэгтэй сайхан санагддаг бол монголчуудад хар үстэй, хөрслөг бор хүүхнүүд маань сайхан харагдаж, хайрлагдан хүндэтгэгддэг юм. Эрдэмтэн Якубовский ч гэсэн Чингис хааны тухай марксист судалгаа хийх гээд чадаагүй юм. Манай монгол түүхчдийн өмнө Чингисийн талаар бодитой, дорвилог, жинхэнэ марксист судалгаа явуулж, зөв зүйтэй дүн шинжилгээ хийж зүй ёсны зохих үнэн зөв ойлголттой болох чухал зорилт тавигдаж байна гэх зэрэг зүйлийг тэмдэглэж ярьсан. Үүний дараа Ш. Лувсанвандан гуай үг хэлмээр байснаа энэ удаа би больё гэж тэргүүлэгчдэд зурвасаар мэдэгдсэн болно.

Бага хуралд дотоодын хэвлэл мэдээллийн төлөөлөгчид, ЗХУ, БНХАУ зэрэг орнуудын элчин сайдын яамны зарим ажилтан, сурвалжлагчид уригдан оролцсон боловч нэг нь цуг хэлээгүй, харин ихэд сонирхон сонсож байв. Гадаадын зочдыг бид мэргэжлийн хэлмэрч нараар тусгайлан бүрэн хангаж чадаагүй, голдуу дэргэд нь суусан орос хэлтэй тохиолдлын зарим хүмүүс санд мэнд дутуу хагас орчуулж өгөхтэй үгүйтэй байсан явдал мэр сэр гарсан нь зарим талын буруу зөв ойлголт гаднын зарим хүнд төрүүлж, тэр нь хэдэн сарын дараа бидэнд гай болсон юм. Тухайн үедээ бид хурал амжилттай болсонд баярлах, оролцсон олон түмэн ч өндөр сэтгэлтэй, баяр баясгалан, яриа хөөрөө болж тарсан.

Тэр хооронд Барилгын яамны Чойжамц даргалж, зураачин, барималч Махбалын удирдан Хэнтий аймгийн Дадал сумын Гурван Нуурын Дэлүүн Болдогт босгуулсан хөшөө бэлэн болсон. Хөшөөн дээрх Чингисийн хөргийг Махбалын зурснаар, «Алд бие минь алжаавал алжаатугай, Ахуу төр минь бүү алдартугай» гэж Чингисийн хэлсэн үгийг Лувсанданзаны Алтан Товчоос Х. Пэрлээгийн шилж дэвшүүлсэн санал ёсоор баталж хийлгэсэн. Уг хөшөө дурсгалыг хэрхэн яаж босгосон, хэзээ яаж хүлээн авсан тухай би тэр үед хийсэн замын тэмдэглэлд тодорхой дурдсанаа ноднин жил тус сэтгүүлийн 2-т хэвлүүлсэн тул энд дэлгэрүүлж ярихыг больё. Мөн тэр үеэр Чингисийн холбогдолтой шуудангийн 8 янзын маркийн цуглуулга гадаадад маш сайхан хэвлэгдэж зохих хувь нь манайд ирэв. Дотоод, гадаадад тараан сурталчлахад зориулагдсан тэдгээр марк дэлхийн зах зээл дээр их үнэд хүрэх сонин зүйл болсон юм.

Чингисийн ойн хурлын материал гурван хувь байсны нэг дээр хөшөө дурсгалын зураг, маркийн загвар зэргийг нэмж оруулан хэвлэлд бэлдээд редакторлуулсны дараа шилжүүлэхээр бэлэн болгосон. Тэр

материалыг редакторлуулсны дараа бусад эхүүд дээр эцсийн засвар хийх гэж байлаа. Гэтэл...

Гэтэл мөн оны намар Чингисийн ойн асуудал бидний санаснаас эсрэг эргэв. Бид бодохдоо түүнийг дээрээс санаачилж, чиглүүлэн зааварлаж хийлгэсэн, ойн үеэр элдвийн харш байдал гараагүй тул буруудна гэж зүүдэнд ороогүй байв. Гэвч нэг мэдэхнээ Хрущев даргын чихэнд монголчууд Чингисийнхээ ойг дэвэргэн тэмдэглэж, орос эмэгтэйг шоолж муулсан гэх зэрэг дүлхэн орчуулгаар буруу ойлгогдсон гажуу мэдээ хүрч гэнэ, тэгээд тэрээр манай даргад хандаж, танай тэнд Чингисийн ой тэмдэглэж, үндэсний үзлийн илрэл цухалзсан юмаа даа гэж асуусан юм гэнэ гэсэн яриа тарав. Түүнийг тийм сүрхий юм болно гэж санаанд үгүй байтал Чингисийн ой хийсэн явдал буруу болж, үндэсний үзэл дэвэргэсэн хэрэгт Д. Төмөр-Очир, Б. Ширэндэв, Ш. Нацагдорж, Ц. Дамдинсүрэн нарыг холбогдуулан, хатуу зэмлэж, буруу шаасан Улс төрийн Товчооны тогтоол гарч ирэв. Академи дээр тусгай цуглаан хийлгэж, УТТ-ны гишүүн Л. Цэнд ирж, тогтоол танилцуулан Нацагдорж, ялангуяа Дамдинсүрэн гуайг ихэд зэмлэн буруушаав. Ширэндэв гуай үнэн байдлыг тайлбарлаж, Нацагдорж гуай «буруугаа» зад хүлээж, өөрийгөө «зарчимчаар» шүүмжилж, Дамдинсүрэн гуай би Чингисийн ой тэмдэглэхэд оролцохгүй гэж далайн давалгаанд үл автах хадан хясаа шиг хатуу зогсож байсан боловч хуралд санамсаргүй орж үг хэлсэн нь үнэн, тэгэхдээ үндсэндээ л үнэн юмыг үнэнээр нь ярихыг оролдсон гэвч мэргэжлийн түүхч биш, бас тэгээд ямар ч бэлтгэлгүй цээжээр ярьсан болохоор эндэж осолдсон зүйл байж болох юм гэсэн утгатай зүйл хэлээд өнгөрсөн. Түүнээс хойш Чингисийн тухай үнэн юм ярихыг дээгүүр доогуургүй бүрмөсөн больсон. Чингис, Монголын байлдан дагуулал, эзэнт гүрэн, ер нь бүх түүх, соёлынхоо талаар үнэн юм ярихаар буруутгаад зогсохгүй, ёс юм шиг заавал хэлмэгдүүлдэг явдал улам улмаар ихсэх болсон учир юу ч ярихыг больсон бөгөөд худал муулах нь шинжлэх ухааны судалгаа, эрдэмтний ёс зүйд харш, үнэн байдалд эс нийцэх тул тэгж нүгэл хийхийг зүрхлэх сэхээтэн яаж тийм олон байх билээ.

Тогтоол гарах үеэр Чингисийн ойн хурлыг Ардын Их Хурлын танхимд хийх санал гарч байсан гэж үнэн үү? Хэн анх тийм санал гар гасан юм бэ? Нацагдоржийн илтгэлд БНМАУ-ыг НҮБ-д гишүүн элсэхэд Чингис хаан Монголын төрийг үндэслэн байгуулсан явдал тус дөхөм болсон гэсэн зүйл орсон байсан гэнэ, тийм зүйл оруулж бичсэн илтгэлийн эх хувилбар нь хаана хэн дээр байна гэж дээр, доор, хажуу хавирганаас эрж сурж байсан боловч манай түүхчид тухайн үед ихээхэн ухамсар бүхий зарчимч эв нэгдэлтэй байсан тул тэр бүхэнд зохих хариу өгч аргацаан өнгөрөөж байж билээ.

Тогтоол гарсны дараа Чингисийн хөшөөг дэлбэлэх, нураах тухай асуудал ч гарч л байсан. Гэвч тэр даруй шууд өгсөн үүрэг, даалгавар байсан эсэхийг мэдэхгүй, ямар ч гэсэн нутгийн ард түмэн ялангуяа Ононгийн буриад нөхөд маань эрс дургүйцэн эсэргүүцсэн учир нурааж чадаагүй өнгөрсөн болно.

Харин манай захиалгаар гадаадад хэвлүүлсэн Чингисийн холбогдолтой маркуудаас Монголын талд хуваарилагдан ирсэн хэсгийг бүгдийг олны нүднээс далдуур шатаасан гэж дуулдаж байсан боловч хожим нь сонсвол зарим байгууллага, хүмүүс түүнийг шатаалгүй, нууцлан хадгалж, аварч үлдээсэн сураг бас байсан. Чингисийн маркийн гадаадад үлдсэн хэсэг нь дэлхийн зах зээл дээр улам улмаар үнэд орсоор одоо ширхэг бүр 150—200 америк доллар болсон байгаа юм.

Тогтоол гарснаас хойш сар гаруй болсны дараа нэг өдөр Төв Хорооноос нэг хүн утасдаж, танай дээр Чингисийн ойн эрдэм шинжил-

гээний бага хурлын материал хэвлэлд бэлдээд байгаа гэнэ, түүний чинь Дарга (Цэдэнбал) үзье гэж байна, яаралтай наашаа хүргүүлээч гэсэн. Уг материалын нэг хувийг хамаг зураг, сэлтийн хамт хэвлэлд үнэхээр бэлдэж дуусаад эцсийн хяналт хийхийн учир бусад хоёр хувь дээр бүрэн буулгаж амжаагүй байсан тул тэр учрыг хэлж, буулган хувилаад хүргүүлье гэж бид хариу өчсөнд та нар дараа буулгаж хувилж амжина, дарга яаралтай үзэх гэж байгаа учир даруй нааш нь хүргүүл, бид осолдож эндэхгүй эргүүлээд та нарт хүргүүлчихнэ, одоо тэр хэвлэлд бэлдсэн ганц хувиа л өгүүлчих гэсэн. Уг хувийг хүргүүлээд 20-иод хоносон боловч эргүүлж өгсөнгүй, дэргэдэх хүмүүсээс нь утасдаж асуухад танилцаж арай дуусаагүй, дуусмагцаа хүргүүлчихнээ, асар удахгүй, та санаа зовох хэрэггүй гэсэн. Дахиад сар гаруй, хүлээж байгаад таг чиг болохоор нь дахин утасдаж асуувал танд эргүүлээд өгнө гэсэн шүү дээ, юунд та байн байн нэхээд байдаг юм бэ гээд утсаа тасалж орхисон. Тэр цагаас хойш Чингисийн ойн материал академид эргэж ирээгүй, хэвлэж ч болохгүй болсон юм. Уг нь тэр хурлын материал Чингисийн асуудалд бодитой хандсан эрдэм шинжилгээний шинэ чухал бүтээл байсан юм. Түүнийг одоо ч аваад хэвлэсэн хаана ч гологдохгүй шинэ баримт, шинэлэг санаа дүгнэлттэй ихээхэн үнэ цэнэ бүхий сонин зүйл байгаа. Тийм ч учраас Цэ. дарга агсаны тэндээс тэр материалыг олж хэвлэн нийтлээд олны хүртээл болгох цаг эрхбиш болсон болов уу гэж бодогдоно.